# 2023 ОНЫ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.01.05 Орхон аймаг

## Нэг. Шалгалтын үндэслэл, зорилго

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн №2 "Шилэн дансны тухай хүүлийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжыг баримтлан, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд дотоод аудит, үнэлгээ хийж, зөрчлийг арилгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

## Хоёр. Шалгалтын явуулсан хугацаа, бүрэлдэхүүн

Шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрүүдэд Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн дарга Г.Галбадрах, улсын байцаагч Б.Дарханбаяр, Д.Энхмөнх нар аудитыг хийж гүйцэтгэн ажилласан.

## Гурав. Шалгалтын дүнгийн талаар

**3.1 Шилэн дансны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал:**

**3.1.1** Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 153 ба мэдээлэлгүй 2 байна.

Хугацаа хоцроож 4 мэдээлэл оруулсан байна. Үүнд :

1. Хагас жилээр мэдээлэх нийт 4 мэдээллийн "Хандив тусламжийн орлого" -ын тайланд оруулах мэдээлэл байхгүйгээ хугацаандаа ил тод болгоогүй байна.
2. Хагас жилээр мэдээлэх нийт 4 мэдээллийн "Сангийн тайлан" -д оруулах файлыг хугацаандаа мэдээлээгүй хоцроосон байна.



3. Жилээр мэдээлэх нийт 11 мэдээллийн "Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт" мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны дотор оруулахдаа оруулах мэдээлэл байхгүй цэсийг тэмдэглээд хадгалсан боловч ил тод болгох цэсийг дараагүйгээс хоцроосон.
4. Жилээр мэдээлэх нийт 11 мэдээллийн "Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан" мэдээллийг 2023 оны 07 дугаар сарын 01-ны өдөр оруулах хугацааг хэтрүүлэн 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр мэдээг оруулж хоцроосон.



**3.1.2** Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан мэдээлэл 153 ба мэдээлээгүй 4 байна.

Хугацаа хоцроож 2 мэдээлэл оруулсан байна. Үүнд:

1. Сар бүр мэдээлэх нийт 5 мэдээллийн "Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - хөтөлбөр, зориулалт" мэдээллийг цаг хугацаандаа

оруулсан боловч механик алдаа гарган оруулсан мэдээллээ дахин хадгалах үйлдэл хийсний улмаас хоцорсон мэдээлэлд орсон байна.



2. Жилээр мэдээлэх нийт 11 мэдээллийн "Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан" мэдээллийг 2023 оны 07 дугаар сарын 01-ны өдөр оруулах хугацааг хэтрүүлэн 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр мэдээг оруулж хоцроосон.



**3.2 Шилэн дансны цахим хуудасны холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг оруулсан байдал:**

**3.2.1** Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр болон Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан гэсэн 2 мэдээлэлд холбогдох тушаал шийдвэрийн хуулбар, баримтыг бүрэн оруулж мэдээлсэн байна.

**3.2.2 Аудитаар илэрсэн шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилттэй холбоотой зөрчлийг бүрэн арилгасан байх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:**

1. Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 оны санхүүгийн болон нийцлийн аудитаар илэрсэн шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж өгсөн. Үүнд:

Зөрчил: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө зарцуулахтай холбоотой 3.6 сая төгрөгний 3 шийдвэрийг мэдээлээгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт зэрэг мэдээллийг 12 дугаар сард хугацаа хоцроож мэдээлсэн, Нийгмийн даатгалын сангийн 13 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны батлагдсан төсвийг мэдээлээгүй байна.

Зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж байх

2. Орхон аймгийн дахь Төрийн аудитын газрын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн хооронд хугацааны нэгдсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд явцын шалгалт хийж шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага өгсөн.Үүнд:

Зөрчил: Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ талбарт 361,282.4 мянган төгрөгийн орлогын гүйлгээг, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт талбарын 1 мэдээллийг хоцроож мэдээлсэн, хандив тусламжийн орлого, хагас жилийн санхүүгийн тайлангийн талбаруудын мэдээг тус бүр мэдээлээгүй.

2023 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг бүрэн оруулж, Нийгмийн даатгалын сангийн 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь өмнөх оноос 69% -иар бууруулж, зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ талбарт мэдээллийг оруулан зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

## Дөрөв. Дүгнэлт

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу төсвийн байгууллага үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн нийт 318 мэдээллээс тухай бүр, сар, улирал, эхний хагас, бүтэн жилээр хуулийн хугацаанд 306 мэдээллийг байршуулан ажилласнаас 6 мэдээллийг хоцроосон байна.

## Тав. Зөвлөмж

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулгыг харгалзах оруулах мэдээлэл байхгүй үед шалтгааныг нь тайлбарлан бичиж, дараалльн дагуу бүх цэсийг бүрэн дарж баталгаажуулах, мэдээ оруулах хуулийн хугацааг өдөр бүр орж шалгаж хэвших

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН:

**ШАЛГАЛТ ХИЙСЭН:**

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН ДАРГА — Г.ГАЛБАДРАХ

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН УЛСЫН БАЙЦААГЧ — Б.ДАРХАНБАЯР

Д.ЭНХМӨНХ